

Батлан МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАД
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДЭД ХОРООНЫ ДАРГА
.....доктор Д.Соронзон



МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН II ДАВААНЫ БАГШ НАРЫН СЭДЭВ

Оноо 50. Хугацаа 150 минут

Санамж:

1. Даалгавруудыг эх сэдэв дээр биш, тусгай цаасан дээр гүйцэтгэнэ.
2. Ажил тус бүрийн дугаар, дэд дугаарыг тодорхой бичнэ.
3. Зарим даалгаврыг эх сэдвээс нь хуулж бичээд хариулаарай.

Даалгавар гүйцэтгэхэд ашиглах эх

До.Болдхуяг

Нүүдэл

Үенчийн говийг саран эцэж гэтэлнэ
Үүрийн жингээр ачаалж нүүдэл хөдөлнө
Өлгийтэй жаалын зүүдийг манаж ганхах нь
Өлжигтэй тэрэг бүүвэйн дуу аялах шиг ээ

Өөшийн говийг наран алжааж туулна
Өглөөний намуунд хөсөг нүүдэл хөвөрнө
Жуумалзан мишээх цовоо сэргэлэн хүүд
Жуузтай тэрэг баатарлаг тууль хайлах шиг ээ

Галбын говийг хулан улдаж барна
Гал үдийн зэрэглээ газар тэнгэрийг хөвөрдөнө
Айлын охиныг мөрөөсөн нүүдэл хөтлөх залууд
Аралтай тэрэг янагийн үлгэр хүүрнэх шиг ээ

Шаргын говийг салхи тамирдаж гатална
Шаргал манхны хээ эвдэж нүүдлийн мөр зурайна
Үдшийн гэгээг эвхэх хижээл эрийн зүрхэнд
Үхэгтэй тэрэг үнэний номыг айлдах шиг ээ

Сүүжийн говийн тэнгэрт эртэч одод түгж
Сүүлчийн тэмээний хонх хэлээ амраана
Сүүн цагаан орчлонг нүүж туулсан өвгөнд
Сүйх тэрэгний мөр хоосон чанарыг үзүүлэх шиг ээ

Нэгдүгээр ажил. Эх, өгүүлбэрийн задлал (24 оноо)

- 1.1. Энэ шүлгийн үүдэл (төрсөн) санаа, сэдвийг товч тайлбарлана уу. (2 оноо)
- 1.2. Шүлгийн гол санааг тодорхойлно уу. (2 оноо)
- 1.3. Энэ шүлгийн үйл явдлыг эхлэл, гол, төгсгөл гэж ангилбал, бадгийн дугаараар тэмдэглээрэй. Яагаад эхлэл, гол, төгсгөл гэснийг товч бичнэ үү. (3 оноо)

1.4. Шүлгийн 5 бадаг тус бүрийн шад тус бүрийг дугаараар нь сонгож 4 бадаг болгож ажиглаад, тус бүрийн гол санааг тайлбарлана уу. (4 оноо)

Загвар нь:

1. Үенчийн говийг саран эцэж гэтэлнэ
1. Өөшийн говийг наран алжааж туулна
1. Галбын говийг хулан улдаж барна
1. Шаргын говийг салхи тамирдаж гатална
1. Сүүжийн говийн тэнгэрт эртэч одод түгж

1.5. Гурав дахь бадгийг яагаад таван бадгийн төвд нь тавьсан юм бол гэж асуувал та юу гэж хариулах байсан бэ? (1 оноо)

1.6. Нүүдэл бол бясалгал гэгээрэлд хүрэх зам юм гэсэн санааг яаж илэрхийлсэн бэ? (1 оноо)

1.7. Энэ эхээс дүрслэх ур маяг (тропы)-ийн жишээ гурвыг олж, ямар ур маяг болохыг нэрлэ. (3 оноо)

1.8. Энэ эхэд найруулах ур маяг (фигуры)-ийн жишээ хоёрыг олж ямар ур маяг болохыг нэрлэ. (2 оноо)

1.9. Энэ шүлэгт дүрслэгдсэн нүүдэл, Д.Батбаярын “Нүүдэл” өгүүллэгт дүрслэгдсэн нүүдэл хоёр ямар ялгаатайг товч өгүүлнэ үү. (2 оноо)

“Нэгэн буурин дээр удахаар газрын үндэс талхлагдаж малын хийморь гунддаг гэж аав ярьдаг сан ...

... Үүрийн харанхуйгаар босож, оосор хошлон тайлан, гэр бараа буулган, тэмээ мал сөглөн, зогсоо зайгүй гүйх амаргүй ч нар цухуйж байхад хуучин нутаг дээрээсээ хөдөлж байх сайхан... (Д.Батбаяр “Нүүдэл” өгүүллэгээс)

1.10. Дээрх шүлгээс харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр тус бүр нэгийг олж, өгүүлбэрийн гишүүдээр зурж гүйцэтгэ. (4 оноо)

Хоёрдугаар ажил. Үг бүтээврийн задлал (10 оноо)

2.1. Шүлгийн нэгдүгээр бадагт орсон нэрлэхийн тийн ялгалтай үгсийг бичнэ үү. (2 оноо)

2.2. Дээрх шүлгээс ойролцоо, төсөөт, эсрэг, зүйлчилсэн утгатай хос үг тус бүр нэгийг олж бичнэ үү. (2 оноо)

2.3. “Өглөө” гэдэг үгтэй түүхэн төрөл үг шүлгээс олж, түүхэн язгуурыг нь бичнэ үү. (1 оноо)

2.4. Шүлэгт орсон “Өлжигтэй тэрэг, жуузтай тэрэг, аралтай тэрэг, үхэгтэй тэрэг, сүйх тэрэг” гэсэн үгсийн утгыг тайлбарлаарай. (2 оноо)

2.5. Дээрх шүлгээс харь гаралтай хоёр үг олж, ямар хэлний үг болохыг бич. (1 оноо)

2.6. “жуумалзан” гэдэг үгийг бүтээврээр задалж бүтээвэр тус бүрийг нэрлэ. (2 оноо)

Гуравдугаар ажил. Онолын даалгавар (6 оноо)

3.1. Б.Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” Хэлбэр судлал . Уб., 1965 бүтээлдээ цэцэг-цэцгүүд, ах-ах нар гэсэн ганц, олон тоог юу гэж нэрлэсэн бэ? (2 оноо)

3.2. Ш.Лувсанвандан 1968 онд бичсэн бүтээлдээ “Үйлийн тийн ялгал, үйлийн хамаатуулах нөхцөл” гэж ямар нөхцөлийг нэрлэсэн бэ? (2 оноо)

3.3. Гурван гишүүнт цөм өгүүлбэр, хоёр гишүүнт цөм өгүүлбэр гэж нэрлэсний учрыг тайлбарла. (2 оноо)

Дөрөвдүгээр ажил. Монгол бичиг (10 оноо)

Дээрх шүлгийн III, IV, V бадгийг монгол бичигт хөрвүүлэн бичээрэй.